



БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 07 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг нэг удаа хийж, 8 асуудал хэлэлцэн, 17 тогтоол гаргаж, хоёр асуудлыг тэмдэглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг чиглэл өгч ажиллалаа. Хурлаар Ардын Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит шагнал олгох тухай, түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хамгаалалтад авах жагсаалт батлах тухай, газрыг тусгай хэрэгцээнд авах тухай, худалдан авах ажиллагааны хагас жилийн ажлын тайлангийн тухай, хөрөнгийн тухай /Хөрөнгө бүртгэлд авах, данс бүртгэлээс хасах, дуудлага худалдаа зохион байгуулах тухай/, иргэний зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх тухай, химийн хорт бодисоор хордсон газрын хөрсийг эрүүлжүүлэх тухай, төрийн өмчит аж ахуйн нэгжийн ТУЗ-ийн зарим гишүүдийг чөлөөлөх тухай асуудал хэлэлцэв.

Тулгар төрийн 2229, Их Монгол Улс байгуулагдсаны 814, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 99 жилийн ойг тохиолдуулан аймгийн хүндэт шагнал “Ардын хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит шагнал”-ыг Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, төрийн соёрхолт яруу найрагч С.Оюун, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Д.Батчулуун, Боловсрол, соёл урлагийн газрын зөвлөх багш Ц.Уранцэцэг нарт хүртээлээ. Хүндэт шагналыг аймгийн баяр наадмын нээлтийн үйл ажиллагааны үеэр гардуулсан.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид аймгийн нутаг дэвсгэр дээрх улсын хамгаалалтад байдгаас бусад түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалалтад авах шийдвэр гаргалаа.

Монгол Улсын соёлын өвийг хамгаалах тухай хуульд зааснаар аймгийн хамгаалалтад авах түүх, соёлын үл хөдлөх дурсгалт 496 зүйлийн талаарх саналыг холбогдох мэргэжлийн байгууллагад уламжлан шийдвэрлүүлэхээр боллоо. Харин ИТХ-ын шийдвэрээр 1174 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг сумын хамгаалалтад авлаа.

2020 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны хагас жилийн явцын тухай аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэдээллийг сонслоо. Нийт 73 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт нь 93,0 хувьтай байна. Тендер зарласан гурав, үнэлгээ хийсэн гурав, гэрээ байгуулсан 61, тендер зарлаагүй зургаан арга хэмжээ байна. Манай аймагт энэ жил орон нутгийн төсвийн 79,0, авто замын сангийн 1,0, орон нутгийн хөгжлийн сангийн 746,9, хандивын 0,5 сая, байгаль хамгаалах сангийн 4,6, улсын төсвийн 8,5 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа юм.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид орон нутгийн өмчийн газарт бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, бүтээн байгуулалтын ажлын үр дүнд хяналт тавихад анхаарах талаар үүрэг чиглэл өглөө.

Иргэний зөвлөлийн гишүүн М.Ганбаатар, Х.Баясгалан, Б.Туяа нарын хугацаа дууссан учир үүрэгт ажлаас нь чөлөөллөө.

Аймгийн ИТХ-ын шийдвэрийг тухай бүр “Bulgan.khural.mn” сайт болон албан ёсны цахим хуудсанд тогтмол мэдээлж байна.

Төрийн захиргааны чиглэлээр:

Булган аймгийн Засаг даргын Тамгын газар “MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага ” стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр 05-р сарын 25-ны өдрөөс 05-р сарын 26-ны өдөр 2 удаагийн сургалт зохион байгуулж, 07-р сарын 06-ны өдрөөс 07-р сарын 08-ны өдөр Төв, Дундговь аймагт туршлага солилцоод ирлээ. “ISO 9001” стандартыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг чанар бүтээмж, төлөвлөлтийн баг, дэмжих үйл ажиллагаа, баримт бичиг боловсруулах баг, дотоод аудитын баг, харилцаа холбоо дотоод сургалтын гэсэн 4 багт хуваагдан, ажлын хэсгүүд чиг үүргийн дагуу ажлаа гүйцэтгэж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын талаар:

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн 70 зорилтын 379 арга хэмжээний хэрэгжилтэд 2017-2020 оны өссөн дүнгээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-ын хуралдаанд танилцуулахаар ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2020 оны эхний хагас жилд 65 тогтоолын 125 заалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 65 зорилтын 101 арга хэмжээг манай аймагт даалгасныг хяналтад авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 2020 оны 07 дугаар сарын 01, 07 дугаар сарын 10-ны дотор хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байршуулж, тайланг АЗДТГ-ын даргын албан тоотоор ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн аймгийн ИТХ, ИТХТ-ийн тогтоол шийдвэрийн биелэлт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ИТХТ-ийн хуралд танилцуулахаар ажиллаж байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн төрийн сангаар үйлчлүүлэгч төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог хийж гүйцэтгэн 1579 ширхэг төлбөрийн хүсэлтээр 6.0 тэрбум төгрөгийн гүйлгээг дамжуулсан байна.

Шилэн дансны 2020 оны 2-р улирлын тайланг гаргаж нэгтгэлээ. Булган сумын ИТХ ЗДТГ, Ойн ангид төлөвлөгөөт хяналт шалгалт хийж дуусгалаа. Ойн анги, ИТХ -д зөрчил илрээгүй бол ЗДТГ-т 60.1 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон байна.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Хульжийн рашааны ордын нөөцийг тогтоох, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн техникийн саналд үнэлгээ хийж, хамгийн өндөр оноо авсан “Монголын гидрогеологчдын холбоо” төрийн бус байгууллага болон “Экотайкүүн” ХХК-ийн түншлэлийн санхүүгийн саналыг 2020.07.08 өдөр нээхээр мэдэгдэл хүргүүлсэн. Газрын 2020 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Сангийн яам болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны 2020 оны 2 дугаар улирал, 6 сарын тайланг гаргаж хүргүүлсэн. Хөрөнгийн үнэлгээ тогтоох ажлын хэсгийг хуралдуулж 1 барилга, 4 тээврийн хэрэгсэлд үнэлгээ тогтоов. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д өөрчлөлт оруулж, алба хаагчдаар хэлэлцүүлэн, газрын даргаар батлууллаа. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгасан Булган сумын гэр хорооллын 200 айл өрхөд боловсон, соруулдаг жорлон барих /Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй төслийн оролцооны хөрөнгө/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээг хийж, ажлын гүйцэтгэгчээр “Энх энгүүн зам” ХХК-ийг сонгон шалгаруулж мэдэгдэл хүргүүлсэн.

Биеийн тамир, спортын газарт ашиглагдаж байсан УАЗ-22069-033 маркийн тээврийн хэрэгслийн дуудлага худалдаанд оролцогч ирээгүй тул үнийг 30 хувь бууруулахаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 07 сарын 08-ны өдрийн хурлаар оруулж батлууллаа. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 301,6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд авах, 3366,9 сая хөрөнгийг данс бүртгэлээс хасах, 63,5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэх, 1,6 сая хөрөнгийг өөрчлөн барих, 90,7 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах шийдвэр гаргуулсан. Булган аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын дэлгэрэнгүй жагсаалтад 5 компани санал ирүүлсэн боловч шаардлага хангасан компани материал ирүүлээгүй, хураангуй жагсаалт үүсээгүй тул дахин зарлаж, 2020.07.26-ны өдөр нээхээр боллоо. Булган сумын 1-р баг Шинэ хороо, Бугат сумын 2-р багийн нутаг дэвсгэр Төлүүгийн даваанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн борлуулах цэг, ариун цэврийн байгууламжийг ашиглах түр журмыг аймгийн Засаг даргаар батлуулж, захирамж гаргасан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан үерийн далан /Булган, Сайхан сум/ барих ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээг хийхэд шаардлага хангасан тендер ирээгүй тул аймгийн Засаг даргад дараагийн шатны арга хэмжээг авч ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн.

Аймгийн татварын хэлтэс нь Улсын төсөвт өссөн дүнгээр 410.7 сая, аймгийн төсөвт 9511.4 сая, сумын төсөвт 868.8 сая, нийт 10790.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.

Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр:

Булган аймаг дахь Төрийн аудитын газраас Тэшиг ус ОНӨААТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас Шүүхийн шийдвэрийн дагуу ажилтан Н.Уянгын 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хүртэлх ажлын 90 хоногийн ажилгүй байх хугацааны нийт 2765430 /Хоёр сая долоон зуун жаран таван мянга дөрвөн зуун гучин / төгрөгийн цалинг байгууллагаас төлж, байгууллагын хохирлыг барагдуулаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоож гардуулсан. 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан балансыг хугацаанд гаргаж, Сангийн яамны Э-Тайлан цахимд шивэв. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл хийж, Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүллээ.

ГУРАВ: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд 3 сумын Засаг даргын 136 захирамж, 45 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж чиглэл хүргүүлэн ажиллалаа.

Дээд шатны байгууллагаас ирүүлсэн 3 албан бичгийн хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.

Иргэдийн хууль ёсны эрхийг хамгаалах, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх зорилтын хүрээнд аймгийн Хууль зүйн туслалцааны төвөөр 12 иргэн үйлчлүүлж, хуулийн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг авсан байна.

Аймгийн хэмжээнд 283 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12 хэргээр буюу 4,42 хувиар өссөн. Илрүүлэлтийн хувь 98,4 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 50 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Баян-Агт, Баяннуур, Бугат, Булган, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Сайхан, Сэлэнгэ, Тэйшиг, Хангал, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгонд урьд оны мөн үеэс өсч, Орхон, Хишиг-Өндөр суманд урьд оны мөн үеэс буурсан байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тухайд 66 бүртгэгдэж, 1 хэргээр буюу 1.49 хувиар буурсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажлын чиглэлээр хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ 2, хорихоос өөр төрлийн ял шийтгэл эдлэсэн иргэдээс торгох ялын 35 гүйцэтгэх хуудасны 94 948 650 төгрөгний үлдэгдэлтэй, нийтэд тустай ажил хийлгэх ялын 6 гүйцэтгэх хуудасны 2236 цагийн үлдэгдэлтэй, эрх хасах ялын 14 гүйцэтгэх хуудасны 6886 хоногийн үлдэгдэлтэй байна. Албадлагын арга хэмжээ авсан тэнссэн 54 иргэн түүнээс хугацааны өмнө тэнсэн суллагдсан 18, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан 6, хөрөнгө орлого хураах 23 гүйцэтгэх хуудасны үлдэгдэл 23, мөнгөн дүн 68 861 000 төгрөг, шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 1 иргэн байна.

Шүүх шинжилгээний албаны чиглэлээр нийт 30 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцож хулгайн 11, зам тээврийнн ослын 7, хүний амь нас хохирсон 11, бусад 1 хэргийн газрын үзлэгт оролцон 968 кадр гэрэл зургаар ул мөр бэхжүүлсэн. Илрүүлсэн гарын мөр 13, гутлын мөр 9, тээврийн хэрэгслийн мөр 18, бичил мөр 2, бусад ул мөр, эд мөрийн баримт 7-г илрүүлж, ажилласан байна. Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр кримналистикийн 2, шүүх эмнэлгийн шинжилгээнд 10, цогцост 8, гэмтлийн зэрэг тогтоох 49, химийн шинжилгээ 19 хийж, нийт 80 үзлэг шинжилгээ хийж, шинжээчийн дүгнэлтийг хугацаанд нь гарган ажилласан.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

Төрсөн-94, гэрлэсэн-11, гэрлэлт цуцалсан-6, үрчилсэн-0, нас барсан-31 хүнийг бүртгэсэн. Шинээр олгосон иргэний үнэмлэх-301, гадаад паспорт захиалга-4, лавлагаа 268-ыг олголоо. Шилжин ирсэн-60, шилжин явсан-167 хүнийг бүртгэлээ.

Эд хөрөнгийн өрхийн бүртгэлийн чиглэлээр:

Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх анхны бүртгэл-21, шинээр өмчлөх эрх-7, барьцаа-5, барьцаанд өөрчлөлт оруулах-2, худалдах, худалдан авах-1 бүртгэлийн ажлыг гүйцэтгэлээ.

Хуулийн этгээдийн эрхийн бүртгэлийн чиглэлээр:

Шинэ бүртгэл-1, нэмэлт өөрчлөлт-3, татан буугдсан-1, тамга тэмдэг-0, лавлагаа 7-г олголоо.

Төрийн архивын чиглэлээр:

Лавлагаа авахыг хүссэн нийт 80 иргэнд /давхардсан тоогоор/ 301 баримтаар үйлчилсэн. Үүнээс 88 хуулбарын лавлагаа, 68 иргэнд цалингийн баримт, 31 иргэнд тодорхойлолт олголоо.

Хөмрөг үүсгэгч байгууллагуудын үйл ажиллагааны явцад хөтөлөгдөж буй баримтын нэр, төрөл, тэдгээрийн хадгалах хугацааны талаарх судалгааг Архивын Ерөнхий газарт хүргүүллээ.

Нөхөн бүрдүүлэлтээр 137 хөмрөгийн Барилга зураг төсвийн 3 байгууллагын 15 хн-ийн 1207 хуудас баримтыг жагсаалт, актаар хүлээн авлаа.

Үндэсний хөтөлбөрийн хүрээнд цахим холболт, программд шивсэн ажлын талаар: /Хө№99/ Рашаант сумын 1-3-р дансны 1987-2011 оны 67 хн-ийн 1592 заалт, 6862 хүний нэр, 237 байгууллагын нэр, 497 газар зүйн нэр, 1966 хуудас, /Хө№38/ Гурванбулаг сумын ЗДТГ-ын 1-р дансны 1953-1986 оны 24 хн-ийн 1153 заалт, 6466 хүний нэр, 121 байгууллагын нэр, 569 газарзүйн нэр, 1464 хуудас, /Хө№188/ Өлзийт хорооны 1-3-р дансны 1989-1997 оны 19 хн-ийн 574 заалт, 2194 хүний нэр, 290 байгууллагын нэр, 31 газарзүйн нэр, 640 хуудас, нийт 3 Хөмрөгийн 110 хадгаламж нэгжийн 3319 заалт, 15522 хүний нэр, 648 байгууллагын нэр, 1097 газарзүйн нэр, бүхий 4070 хуудас баримтыг АМС программд тодорхойлон бичлээ.

Онцгой байдлын талаар:

Гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалт, сургалт, сурталчилгааны чиглэлээр:

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Эрүүл мэндийн байгууллагуудад "Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдөр хүртэл зохион байгууллаа. Уг хяналт шалгалтад аймгийн Нэгдсэн эмнэлэг, "Сожид", "Энх-Үрс", "Цан-Лэг", "Ман-Од" эмнэлэг, "Цоожэд", "Эмийн цэцэглэн" өрхийн эмнэлэг, Эрүүл мэндийн газар зэрэг объектууд хамрагдлаа. Шалгалтын явцад нийт 8 эрүүл мэндийн байгууллагын 12 объект хамрагдаж гамшиг осол, гал түймэр гарч болзошгүй 70 зөрчил дутагдал илрүүлснээс 22-ыг шалгалтын явцад арилгаж, цаг хугацаа, хөрөнгө хүч шаардсан 48 зөрчлийг арилгахаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн 6 албан шаардлага, 2 мэдэгдэл бичиж хүргүүлэн биелэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

"ЭЕШ-ыг зохион байгуулах үед коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх түр журам"-ын хэрэгжилтийг 2020 оны 07 дугаар сарын 2-нд Булган аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн хичээлийн байранд зохион байгуулж, түр журмын 2.8 дахь заалт шалгалт зохион байгуулагч, багш, ажилтан, шалгуулагчдын гар угаах нөхцөлийг бүрдүүлж, ариун цэврийн өрөөнд гар угаах шингэн саван, гар арчих цаасан алчуур, гар халдваргүйжүүлэх уусмалыг байршуулах заалт хангалтгүй хэрэгжсэн зөрчил илэрснийг арилгах зөвлөмж өгч, шаардлага тавилаа.

Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл 13, гал түймэр гарсан тухай акт 1, гал гарсан зөрчлийн тэмдэглэл 1/хохиролгүй/, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 8, дүгнэлт 3, шинжээчийн дүгнэлт 2, зөвшөөрөл 1, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт 6, барилгын зураг хянасан дүгнэлт 3, танилцуулга 1-ийг бичиж ажиллалаа.

Гал түймрийн 2 зөрчилд зөрчлийн хэргийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэж зөрчлийн холбогдогч 2 хүнд зөрчлийн тухай хуулийн 5.14-р зүйлийн 1 дэх хэсгийн дагуу тус бүр 100 нэгжийн шийтгэлийн арга хэмжээг авч хяналтын прокурорт хянуулсан.

Газрын хэмжээнд объектын гал түймэр 2, усны ослын дуудлага 1 удаа ирж, гамшгийн голомтод онцгой байдлын газраас 38 хүн, 6 автомашин, ЗХ-ний 234 дугаар ангиас 45 хүн, 1 техник үүрэг гүйцэтгэж ажилласан. Мал, амьтны гоц халдварт галзуу өвчний 2 мэдээлэл ирж,

орон нутгийн гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн 2 автомашинтай 5 хүн үүрэг гүйцэтгэж ажиллалаа.

Бэлтгэл бэлэн байдал, гамшигтай тэмцэх үйл ажиллагааны талаар:Нэгдсэн арга хэмжээний хүрээнд Хангал сумын Хялганат тосгоны гүүр Сэлэнгэ мөрөн, Хутаг-Өндөр сумын Уньт багийн Гуртын гүүр Сэлэнгэ мөрөн_ Орхон сумын Мандал багийн Орхоны гүүр Орхон голд Онцгой байдлын газрын Эрэн хайх аврах салбар, Гал түймэр унтраах, аврах 20, 50 дугаар анги, сумдын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн хамтран гол мөрөнд иргэд олноор цуглардаг, зорчдог, хөл хөдөлгөөн ихтэй газарт явганаар болон завьтай эргүүлийг ажиллуулж,нийт 869 хүнд архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ усанд орохгүй байх , бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх талаар зөвлөмж, сэрэмжлүүлэг өгөв.

ДӨРӨВ: БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Эрүүл мэндийн талаар:

Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглагдаж байгаа мэдээллийн технологийн техник, тоног төхөөрөмжид гарсан өөрчлөлтийг [heps.hdc.gov.mn](https://hdc.gov.mn) программд 2020 оны эхний хагас жилийн байдлаар бүртгэж, мэдээллийн сан үүсгэн хянаж, мэдээг ЭМХТ-д 01/314 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2020 оны 07-р сарын 16-ны өдөр сумдын ЭМТ-ийн эрхлэгч, статистикч эмч нийт 30 төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулан чадавхжуулж, гарын авлага номоор хангалаа.

Өрх хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагын 12 эмч, мэргэжилтэнд тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг цэвэрлэх, халдваргүйтгэх, савлах ур чадварыг эзэмшүүлэх үзүүлэх дадлага, сургалтыг зохион байгууллаа.

“Коронавирус халдвар (COVID19) -ын сэргийлэлт, хяналт, эмнэлзүйн менежмент” сэдэвт ажлын байрны сургалтаар бэлтгэгдсэн аймгийн 22 сургагч багш ЭМГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 01/298 тоот албан бичгийн хөтөлбөр, хуваарийн дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээнд доголдол үүсгэхгүйгээр ажлын байрны зохицуулалтыг хийж, 10 суманд ажиллаж, ЭМТ-ийн 335 эмч, мэргэжилтэнд болон сумдын ИТХ, ЗДТГ, сургууль, цэцэрлэгийн төлөөлөл, сумын нийгмийн ажилтан зэрэг 74 ажилтан, албан хаагчид аймгийн төвд Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эмнэлэг, эмийн сангийн 120 эмч, мэргэжилтэн, ажилтанг хамруулсан сургалт зохион байгууллаа.

Цоожэд, Эмийн цэцэглэн өрхийн эмнэлэг болон Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүдэд 2020 оны 07-р сарын 23-ны өдөр дотоодын хяналт, шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх 14 хоногийн аян зарлан даатгалгүй иргэдийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг сумдаас авч нэгтгэн ЭМЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт 02/315 тоот албан бичгээр хүргүүлэв. Аяны хугацаанд алслагдсан сум, багт амьдарч буй 65 иргэнийг эрүүл мэндийн даатгал, В,С вирусын илрүүлэг шинжилгээнд хамруулсан. 395 зөвлөгөө, зөвлөмж, мэдээллийг цахим хуудсанд байршуулж, иргэдэд мэдээ мэдээллийг хүргэж байна.

Улс орон даяар “Элсэлтийн ерөнхий шалгалт” зохион байгуулсантай холбогдуулан, коронавирус халдвар (COVID19) –аас урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийг аймгийн 1 дүгээр

сургуулийн 1500мкв талбайд хийж, ЭМГ-ын 3 мэргэжилтэн ЭЕШ-ын хугацаанд багш, сурагчдыг халдвараас сэргийлэх, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг баримтлуулан хянаж ажиллалаа.

Аймгийн баяр наадмын үеэр иргэдийн биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэн зөвлөгөө, мэдээлэл өгч, гарын авлага тараан, халдвар судлагч нарт хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан.

Геронтологийн үндэсний төвтэй хамтран “Хүн амын насны доройтлын тархалт, нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийн судалгаа” сэдэвт үндэсний хэмжээний судалгаанд Булган сумын 150, Сайхан, Хялганат сумын 150 ахмад настныг хамрууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 2020 оны 7-р сарын байдлаар 2031 иргэн ажил хайгчаар бүртгэлтэй байгаагаас шинээр 1543 иргэн идэвхтэй ажил хайгчаар бүртгүүлсэн байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн бага буюу боловсролгүй иргэд 16%, бүрэн дунд боловсролтой 63,7%, дипломын болон бакалаврын дээд боловсролтой 10,9%, тусгай болон техникийн мэргэжилтэй 9.4%-ийг эзэлж байна. Нийт иргэдийн 82%-ийг 25-54 насныхан эзэлж байна.

Ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг нийт 14 иргэнд гарган, Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн. Ажил олгогч 8 байгууллагаас 18 ажлын байрны захиалга авч, Орон нутгийн телевиз болон зарын цэгүүдээр зар сурталчилгааг явуулж ажиллалаа.

Шинэ ажлын байр: Шинээр бий болж байгаа ажлын байранд 123 иргэн орж ажилласнаас байнгын ажлын байранд 26 иргэн, улирлын ажлын байранд 19 иргэн, түр ажлын байранд 78 иргэн зуучлагдан ажиллав.

Ажилд зуучлагдсан иргэн: Ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын сул чөлөөтэй ажлын байранд 73 иргэн зуучлагдснаас байнгын ажлын байранд 11 иргэн, улирлын ажлын байранд 19 иргэн, түр ажлын байранд 43 иргэн зуучлагдан ажилласан.

Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэн 385 иргэнийг түр ажлын байраар ханган, ажлын хөлсөнд 66,7 сая төгрөгийг зарцуулсан.

“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 51 иргэнийг 185,5 сая төгрөгөөр дэмжин, гэрээ байгуулан, санхүүжилтийг олгов.

“Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн малжуулах арга хэмжээнд хамрагдсан иргэдтэй гэрээ байгуулан, Бугат, Хангал, Хялганат, Сэлэнгэ сумаас хамрагдсан иргэдэд 57 үхэр, 82 хонь, 145 ямаа худалдан авч хүлээлгэн өглөө.

“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний тариалах арга хэмжээнд Баян-Агт сумын сонгинын үр авсан иргэний 2,9 сая төгрөгийг олгосон.

“Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр”-ийн бичил зээлийг дэмжих арга хэмжээний хүрээнд 7 сард 3 иргэний төсөлд 20 сая төгрөгөөр дэмжин санхүүжилтийг олголоо.

Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 301 иргэнд үзүүлж, мэдээг 07-р сарын 25-нд ХХҮЕГ-т хүргүүлсэн.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон хамтын гэрээ, хөдөлмөрийн тухай хуулийн асуудлаар 2 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгсөн.

Автозамын салбарын ХАБЭА-н улсын үзлэгийг 4 компанид хийж, тайланг АЗДТГ болон ХНХЯ-д хүргүүллээ.

31 төрлийн тендерийн ажилд 82 компанитай ажиллах хүч нийлүүлэх гэрээ байгуулан ажиллалаа.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Шинэ төрсөн 81 хүүхдийг өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэнээс 11 хүүхэд гадаадад бүртгэлтэй, 5 хүүхдийг бусад аймаг, дүүрэгтэй холбогдож, ӨМНС-д бүртгэсэн. Нэр өөрчлөгдсөн 2 хүүхдийн бүртгэлийг хийж, ӨМНС-д бүртгэлгүй 2 хүүхдийн мэдээллийг “Хүүхдийн мөнгө” функцын жагсаалтад орууллаа.

Өрхийн мэдээлийн нэгдсэн санд бүртгэлгүй 14 өрхөөс өргөдөл, хүсэлт хүлээн авч, 14 өрхийг амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамруулж, мэдээллийн санд бүртгэсэн.

Шүүхэд нэхэмжлэл гаргах, өмгөөллийн хөлснөөс чөлөөлөгдөх, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд хамрагдах зэрэг шалтгаантай 1 иргэнд амьжиргааны түвшний тодорхойлолт гаргаж өгөв.

ӨМНС болон хүүхдийн мөнгө, хүнсний эрхийн бичиг, бусад үйлчилгээтэй холбоотой асуудлаар зөвлөгөө, мэдээлэл авахаар биечлэн ирж уулзсан 24 иргэнд, утсаар холбогдсон 8 иргэнд мэдээлэл өгч ажиллалаа.

Халамжийн сангийн 2020 оны 7-р сарын санхүүжилтыг хийж мөнгийг олгосон. 2020 оны 1-6-р сард хүнс олгосон дэлгүүрүүдтэй тооцоо нийлж, хүнсний олголтын мөнгийг олгосон. 2019 оны санхүүгийн тайлангийн Аудитын зөвлөмжийн дагуу өглөг, авлага барагдуулах талаар тооцоог гаргаж авлагыг барагдуулан, Аудитад зөвлөмжийн хариуг хүргүүлсэн. Халамжийн сангийн 2019, 2020 оны эхний хагас жилийн гүйцэтгэл, 2021 оны төсвийн төслийг гаргаж, ХХҮЕГ, аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.. Халамжийн сангийн орон нутгийн болон улсын төсвийн мэдээ тайланг гаргаж, ХХҮЕГ, Төрийн сан, Статистикийн хэлтэст хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бүтэн өнчин хүүхэд, өрх толгойлсон эх, нэн ядуу амьдралтай иргэдэд Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээг хүргэн эхний 6 сард дараах үйлчилгээг үзүүлээд байна.

Үзүүлэлт	Хүний тоо	Өртөг /мян.төг/
Халамжийн тэтгэвэр	1117	1295848,6
Халамжийн тэтгэмж Үүнээс	2642	729143,4
Ахмад настанг асарч буй иргэнд НМТ	957	437348,9
ХБ-тэй иргэнийг асарч буй иргэнд НМТ	350	153707,3
Байнгын асаргаатай ХБ-тэй хүүхэд НМТ	189	127254,3
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч ө/тэтгэмж	26	10833,0
Ахмад настанд үзүүлсэн тусламж /хөнгөлөлт	934	76751,0
ХБ-тэй иргэнд үзүүлсэн тусламж /хөнгөлөлт	219	32974,8
Амьжиргаа дэмжих сангаас олгосон/тусламж	1409	356863,6
Алдарт эхийн одон	5500	703800,0
Хүнс тэжээл хөтөлбөр	4561	439536,0
Алдар цолтой ахмад	29	27600,0
Цалинтай ээж	681	129316,5

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:

НҮБ-ийн хүүхдийн эрхийн сангийн дэмжлэгтэйгээр хүүхэд хамгааллын мэргэжилтэн болон нийгмийн ажилтан Улаанбаатар хотод сургалтад хамрагдаж, 4 дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төв болон хамгаалах байрны үйл ажиллагаатай танилцсан.

Гэр бүлийн хөгжил хамгааллын алба:

- Шүүхийн захирамжаар гэр бүл салалтад шинжээчийн дүгнэлтийг 2 гэр бүлд гаргасан.
- Цагдаагийн газрын хүсэлтийн дагуу хүүхэдтэй холбоотой 3 гэмт хэрэгт албан ёсны төлөөлөгчөөр ажиллаж байцаалтад оролцсон.

Хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын алба:

- Улсын баяр наадмыг тохиолдуулан хурдан морины уралдаанч хүүхдийн бүртгэл хийж, хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. Мөн Булган аймгийн 16 сумын хэмжээнд сумдын баяр наадамд хурдан морь унасан уралдаанч хүүхдийн мэдээллийг нэгтсэн санд оруулсан. 2020 онд аймгийн хэмжээнд нийт 2360 хурдан морь уралдаж, 660 уралдаанч хүүхэд оролцсон байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Мал аж ахуйн талаар :

Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нэгдсэн төлөвлөгөөний дагуу нийт суманд хадлан, тэжээл бэлтгэлийн ажлыг чанартай зохион байгуулах, малдаа хүрэлцэхүйц хэмжээний өвс, тэжээлийг бэлтгэж, нөөцлөх, худаг уст цэгийн эзэмшилт, ашиглалт, хашаа хорооны хангамжийг сайжруулах, мал эмнэлгийн үйл ажиллагааг технологит хугацаанд нь дуусгах, эр сувай малыг борлуулах, зам даваа хаагдаж болзошгүй газарт өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдын хувийн бэлтгэлийг сайтар хангуулах зэрэгт тодорхой чиглэл өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 3.6 сая толгой мал өвөлжиж, хаваржсанаас тэмээ 1452, адуу 272.0 мянга, үхэр 282.3 мянга, хонь 1923.8 мянга, ямаа 1162.0 мянга байна.

Нийт 1651.3 мянган хээлтэгч төллөхөөс 73.8 хувь буюу 1218.3 мянган хээлтэгч төллөснийг төрлөөр нь авч үзвэл ингэ 171, гүү 55414, үнээ 74665, эм хонь 714145, эм ямаа 373925 байна. Гарсан төлийн 93.5 хувь буюу 1138.5 мянган төл бойжиж байна. Ботго 97.1%, унага 97.2 %, тугал 98.1%, хурга 92.6 %, ишиг 93.7% байна.

Том малын зүй бус хорогдол адуу 9.5 мянга, үхэр 8.7 мянга, хонь 73.4 мянга, ямаа 30.5 мянга, 122.3 мянган толгой мал буюу нийт малын 2.4 хувь нь хорогдсон байна.

Хадлан, тэжээл бэлтгэлийн талаар :

Аймгийн хэмжээнд малчдын хүчээр 111.2 мянган тонн байгалийн хадлан, 1.2 мянган тонн ногоон тэжээл, 8.4 мянган тонн үйлдвэрийн тэжээл, 1.6 мянган тонн гар тэжээл, 10.1 мянган тонн давс хужир, шүү бэлтгэх төлөвлөгөөг сумдад хүргүүлээд байна.

Аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх талаар сумдад чиглэл өгч, цаг алдалгүй шуурхай зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Аймгийн хэмжээнд хадлан бэлтгэлийн ажилд дугуйт трактор 154, трактор хадуур 62, трактор тармуур 63, хаман боогч 28, гар хадуур 1159, бага оврын трактор хадуур 1040, хүн хүч 3704 ажиллах тооцоо судалгаа гаргасан.

Хадлангийн ургац муу байгаа урд бүсийн Рашаант, Гурванбулаг, Дашинчилэн сумын малчдын хэрэгцээт өвсийг Сэлэнгэ, Бугат, Хангал, Тэшиг, Хутаг-Өндөр сумаас, бусад 12 сумыг өөрсдийн хэрэгцээт хадланг бэлтгэх ажлыг зохион байгуулж байна.

Хүнс, газар тариалангийн талаар:

Хаврын тариалалтаар нийт 46640.6 га-д тариалалт хийснээс үр тариа 38295 га-д, үүнээс улаан буудай 37380.5 га, бусад үр тариа 915 га, ногоон тэжээл 3000 га-д, тосны ургамал 4987 га-д, төмс 552.5 га-д, хүнсний ногоо 156.7 га-д тариалсан байна.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Аймгийн хэмжээнд мал эмнэлгийн гэрчилгээ нийт 687 ширхэг бичигдсэнээс амьд мал 5851 толгой, мах 51377 кг, айраг 2880 литр, ноос 48,6 тн, сүү 350 литр, тараг 20 литр, ааруул 250 кг, шар тос 8 кг, цөцгий 60 кг байна.

Мал эмнэлгийн 57 дуудлагад малын эмч нар явж үйлчилсэнээс галзуу өвчин, халдваргүй, эндемик өвчний шинж тэмдэгтэй дуудлага их ирсэн байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2021 оны захиалгыг сумдын МЭТ-аас авч нэгтгэн Засаг даргаар батлуулан, МЭЕГ, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Үүнд: Нийт 13 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 2,5 сая мал хамруулахаар төлөвлөсөн.

Нян судлалын шинжилгээ: Мал амьтны өвчний онош тогтоох шинжилгээнд Баян-Агт, Могод, Орхон, Сайхан сумаас нийт 24 дээж ирж шинжилгээнд хамрагдсан. Орхон сумын Бүхт баг, Баян-Агт сумын Халтар багт галзуу өвчин гарч хязгаарлалтын дэглэм тогтоож ажилласан бөгөөд Орхон сумын Бүхт багт гарсан галзуу өвчний хязгаарлалтын дэглэмийг сумын Засаг даргын 2020 оны 07-р сарын 23-ны өдрийн А/207 тоот захирамжаар, Баян-Агт сумын Халтар багт гарсан Галзуу өвчний хязгаарлалтын дэглэмийг сумын Засаг даргын 2020 оны 07 -р сарын 24-ны өдрийн А/130 тоот захирамжаар тус тус цуцалсан.

Ийлдэс судлалын шинжилгээ: Ийлдэс судлалын шинжилгээнд адууны нийлүүлгийн өвчин, бог малын мялзан өвчин, бруцеллёз өвчний тандалт шинжилгээг 251 дээжид хийсэн.

Бог малын мялзан өвчний халдварын байдлыг тандах өвчингүй тайван бүс болохыг нотлох тандалтыг ажлыг Орхон сумын Бүхт, Мааньт багт хийсэн. Энэ шинжилгээнд 10 өрхийн хонь 120, ямаа 120 нийт 240 бог малаас цус аван ийлдсийг стандарт арга зүйн дагуу авч шинжилгээнд бэлтгэсэн.

Ариун цэврийн шинжилгээнд: Нийт 89 дээжид шинжилгээ хийснээс махны дээж 60, айрагны дээж 2, сүүний 27 дээжийн дүнг олгон ажиллалаа.

Мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаа:

Аймгийн баяр наадмын хурдан морины комисст лабораторийн 3 эмч ажиллаж баяр наадмаар ажилласан цайны газар, хуушуурын гуанз ажиллуулсан иргэдээс ирүүлсэн махны дээжид ариун цэврийн шинжилгээ хийсэн.

Булган, Орхон, Бугат, Бүрэгхангай сумдын 7 багийн 13 өрхийн 180 малаас дээж авч, Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын мониторингийг зохион байгуулсан.

Шинжилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор 4 удаа тэжээлт орчин хийх эм уусмал найруулах ажил хийж, ажлын шил сав угаах, халдваргүйжүүлэх ажлыг цаг тухайд хийж шинжилгээний бэлэн байдлыг тухай бүр нь хангаж ажиллалаа. МПА 1,8 л, МПБ 1,5 л, эндо агар 0,3 л хийсэн.

Гуртын гүүрэн дэх хяналтын цэгээр тайлант хугацаанд 216 тээврийн хэрэгслээр адуу-50, үхэр-286, хонь-6306, ямаа-1077 толгой, бусад арьс шир, цагаан идээ, дайвар бүтээгдэхүүн үхрийн мах-120008 кг, ямааны мах-165 кг, хонины мах-9150 кг, адууны мах-950 кг, гахайны мах-400 кг, дайвар бүтээгдэхүүн-200 кг, ноос-300 тн, ноолуур-500 кг, дэл сүүл-3700 кг тээвэрлэгдэн гарсныг шалгаж нэвтрүүлээ.

ЗУРГАА: БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР:

Байгаль орчны чиглэлээр:

Тэшиг сумын “Баян шинэс” ХХК, “Монгол гео каратаж” ХХК-ийн “Зүсмэл материал үйлдвэрлэх” төслийн 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж хүргүүлээ. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох чадавхыг бэхжүүлэх” буюу NAP төслийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөлтийн явцын протоколыг танилцуулах цахим хуралд оролцлоо. Орхон сумын 2-р багийн нутагт унд, ахуйн зориулалтаар худаг гаргах хүсэлт ирүүлсэн 1 аж ахуйн нэгжид 3 худаг гаргах зөвшөөрөл олголоо. Хутаг-Өндөр сумын “Их булаг”-ийн рашааныг түшиглэн амралт, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж буй иргэд, аж ахуйн нэгжүүдэд “Жорлонгийн шинэчлэл”-ийн талаар мэдээлэл өгөх уулзалтад тус газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн оролцож, ус ашиглах дүгнэлт гарган зөвшөөрөл авч, гэрээ байгуулж ажиллах зөвлөмжийг өгч, харилцан санал солилцлоо. Амралт, рашаан сувиллын үйл ажиллагаа явуулдаг 5 аж ахуйн нэгж, 6 иргэнд Усны тухай хууль, тогтоомжийг сурталчилж, ус ашиглах дүгнэлт гаргах талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Царам, Өрөмийн голын чиглэлд хяналт шалгалт хийж, 7 өрхийн 18 хүнд хуулийн зөвлөгөө өгч ажиллав. “Гранд порист” ХХК нь 1200-аад ойн хортны тэмцлийн ажил онгоцоор хийж гүйцэтгэсэн. Орхон голын сав газрын захиргаанаас 2021 онд худаг гаргах, хаших булгийн судалгааг хийх зорилгоор газрын байршлыг тогтоож байна.

Хөх чулуутын эхэнд ойн цэвэрлэгээний тусгаарлалтыг 6,5 га-д хийлгэсэн.

БОХУБ, Байгаль хамгаалагч нартай хамтран ангийн эргүүл хяналтыг 7 сарын 7,8-ны өдөр Дулаанхаан, Шарга багт хийж зөвшөөрөлгүй тарвага агнасан 3 зөрчил илрүүлж, БОХУБ-аар шийтгэврийн хуудас бичүүлэн нөхөн төлбөр, торгууль төлүүлж арга хэмжээ авлаа. Эргүүл шалгалтаар явж, малчин иргэдэд болон гэрээгээр ажиллаж байгаа нөхөрлөлийн идэвхтэн байгаль хамгаалагч нарт хулгайн ан, үер усны аюулаас сэрэмжтэй, анхаарал болгоомжтой байж машин, мотоциклтой иргэдэд хараа хяналт тавих, номер дугаарыг тэмдэглэж байх талаар мэдээлэл хүргэв. Баян, Өргөө булаг, Дарь-Эхт нөхөрлөлд цэвэрлэгээ болон хэрэглээний ажлын тусгаарлалт хийлгэн мод бэлтгэлд хяналт тавих гэрээ хийв. Аймгаас байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр нэг булгийн эхийг хаших ажлыг хийв. “Байгаль орчин тогтвортой хөгжлийн санаачилга” ТББ-тай хамтарч хортон шавжийн судалгаа хийж тэмцлийн ажлыг хийх газраа сонголоо. Хууль бус мод бэлтгэж байсан иргэнийг шалгалтаар илрүүлж, цагдаад хүлээлгэн өгөв. “Илчит хөлөг” ХХК нь төлөвлөгөөт бус шалгалтаар /хяналтын хуудсаар/ 85 хувиар үнэлэгдлээ.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр:

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын чиглэлээр: Булган аймгийн газар нутгийг илэрхийлсэн самбарыг Орхон аймагтай залгаа хил орчмын бүсэд байршуулах ажлыг хийж

гүйцэтгэсэн талаарх тайланг 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулан танилцууллаа.

Булган аймгийн Булган, Тэшиг, Могод, Гурванбулаг суманд ашиглагдаж буй цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбайг Улсын тусгай хэрэгцээний газарт хамруулахаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулан Засгийн газарт уламжлав.

Иргэдээс хүний нөөцийн асуудлаар-2, барилгын чиглэлээр-1, газрын чиглэлээр үйлчилгээ авахаар ирүүлсэн-4 өргөдөл, хүсэлтийг зохих хууль журмын дагуу бүртгэлжүүлэн, хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг хүргэлээ.

Газар зохион байгуулалтын чиглэлээр:

2020 оны 2-р улирлын байдлаар **54** иргэн өргөдөл ирүүлснээс **13** иргэнд **1.36** га газрыг өмчлүүлж, өссөн дүнгээр **15107** иргэн өргөдөл ирүүлснээс **15107** иргэнд **2446.7** га газрыг өмчлүүлж статистикийн 2018 оны 62214 иргэнд харьцуулахад газар өмчлөлийн ажил 24.3 хувьтай байна. Сумдаар авч үзвэл: Булган сумын **7** иргэнд **0,65** га, Орхон сумын **2** иргэнд **0,11** га, Сайхан сумын **4** иргэнд **0,56** га газар өмчлүүлж, бусад суманд газар өмчлөх шийдвэр гаргаагүй байна.

Газрын төлбөр, үнэлгээний чиглэлээр:

Аймгийн хэмжээнд 2020 онд нийт газрын төлбөрт 505 сая төгрөг, дуудлага худалдаанд 20 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 7-р сарын 20-ны байдлаар газрын төлбөрт 287,6 сая төгрөг дуудлага худалдаанд 93,4 сая төгрөг нийт 381,5 сая төгрөг аймаг орон нутгийн төсөвт төвлөрөөд байна.

Өмчилсөн газрын татварын итгэлцүүрийг кадастрын мэдээллийн санд оруулах ажлыг 16 сумын хэмжээнд хийж дуусгалаа.

Булган сумын 6-р баг Залуус-1-д авто гараашны зориулалтаар 2 нэгж талбар газрыг дахин дуудлага худалдаанд оруулж, иргэн Г.Энхтайван 1780,0 мянган төгрөг, иргэн Б.Бурмаа 1280,0 мянган төгрөгөөр ялалт байгуулан, гэрээг байгуулж нийт 3060.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээд байна.

Стандарт, хэмжил зүйн талаар:

Шилэн дансны улирлын тайланг СХЗГазар, Аймгийн Санхүү, хяналт аудитын албанд хугацаанд нь хүргүүлэв.

Улсын их баяр наадмын үеэр мах махан бүтээгдэхүүн хадгалах, хуушуур худалдан авахад анхаарах зүйлсийн талаар зөвлөмж боловсруулан Булган аймгийн Мэргэжлийн хяналтын газрын цахим хуудсаар сурталчилан аж ахуйн нэгж, иргэдэд гарын авлага болгон тараалаа.

Баталгаажуулалтын зөвлөлийн хурал хуралдан, 8 аж ахуй нэгжид үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээ олгов.